

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Т.Тамир (ШУТИС-ийн багш, Бизнесийн удирдлагын магистр)


2023-10-24

Оршил

- Судалгааны зорилго:
 - Энэхүү дүн шинжилгээгээр 2024 оны хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн анхны өртөг 2024 оны төсөвт тусахдаа өөрчлөгдсөн байдлыг судаллаа.
- Хамрах хүрээ:
 - Дүн шинжилгээнд 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад багтсан хөрөнгө оруулалтын 552 төслийг хамрууллаа.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТОЙМ


Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд туссан хөрөнгө оруулалтын төсөвт өртөг (их наяд төгрөгөөр)




2024 оны төсвийн төслийн төсөлд тусгасан шинэ, шилжих төслийн харьцаа, бүтэц (их наяд төгрөгөөр)

	Барилга байгууламж	Их засвар	Тоног төхөөрөмж	ТЭЗҮ
Шинэ төсөл	3.53	0.05	0.35	0.07
Шилжих төсөл	4.56	0.08	0.47	0.01


2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилт, төсвийн ерөнхийлөн захирагчдаар (сая төгрөгөөр)



ХОЁР. 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ ӨССӨН БАЙДАЛ



2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн тоо, төсөл эхэлсэн оноор




2024 оны төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн тоо, төсөл эхэлсэн оноор (тэрбум төгрөгөөр)

Он	2024 оны төсөвт өртөг	Анхны төсөвт өртөг	
2010	28.6		4.4
2011	66.9		20.8
2012	25.2		11.1
2013	10.6		2.2
2014	74.0		33.3
2015	21.3	Σ 226.6	12.9
			Σ 84.7
2018	85.4		107.9
2019	567.8		360.4
2020	645.8		432.3
2021	527.5		335.4
2022	2568.1		2070.6
2023	501.3		501.4


2024 оны төсөвт өртөг нь анхны өртгөөсөө өссөн шилжих төслийн тоо



Төслийн анхны өртөг 2024 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд хамгийн их өсөлттэй 10 шилжих төслийн тоо, төсвийн өссөн дүн (Төсвийн ерөнхийлөн захирагчаар)



2024 оны төсвийн төсөл дэх анхны төсөл хамгийн их дүнгээр өссөн 10 төсөл (Тэрбум төгрөгөөр)



Жич: Хэвтээ тэнхлэгт төсөл эхэлсэн оныг харуулав.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

- Хөрөнгө оруулалтын шилжих төсөл Монгол Улсын төсвийн төслийн нийт төслийн 52.6 хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын шилжих 552 төсөл байгаагаас 373 төслийн анхны төсөвт өртөг 2024 оны төсвийн төсөлд өссөн дүнтэй байна. Шилжих төслийн анхны өртөг нь 2024 оны төсвийн төсөлд 3 тэрбум төгрөгөөс илүү дүнгээр туссан 91 төсөл байгаагаас тал хувь нь 3-6 тэрбум төгрөгөөр өссөн, 15 тэрбум төгрөгөөс дээш дүнгээр өссөн байна. Үүнээс хамгийн их мөнгөн дүнгээр өссөн төсөл 80 гаруй тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Хөрөнгө оруулалтын шилжих төслийн анхны төсөв 2024 оны төсвийн төсөлд хамгийн их өссөн 5 төслийн 2 төслийн хугацаа өөрчлөгдөөгүй бол 3 төслийн дуусах хугацаа 1 жилээр урагшилсан байна. Төсөл эхэлсэн хугацаанаас хойшхи нийт санхүүжилт төслийн төсвийн хэмжээнд хүрээгүй тул хугацаа урагшилсан шалтгааныг тогтооход шаардлагатай мэдээлэл байхгүй байна.
- Хөрөнгө оруулалтын шилжих төслийн 90 гаруй хувь нь барилга байгууламжийн төсөл эзэлж байна.
- Барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын 2024 оны төсвийн төсөл дэх хөрөнгө оруулалтын дүн анхны өртгөөсөө өссөн байхад ТЭЗҮ буурсан байна.
- 552 шилжих төслийн 14 төсөл нь 2010-2015 онд эхэлсэн төсөл байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчаар ангилбал анхны өртөг нь 2024 оны төсвийн төсөлд хамгийн их дүнгээр өссөн төсөл Боловсрол, шинжлэх ухааны сайд; Зам, тээврийн хөгжлийн сайд; Соёлын сайд; Эрүүл мэндийн сайдад хамаарч байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- Үндэсний статистикийн хорооны вебсайт.
<https://www.1212.mn/mn>
- Төсвийн тухай Монгол Улсын хууль
- Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн баримт бичиг
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем.
Монгол Улсын Сангийн Яам (publicinvestment.gov.mn)

Анхаарал хандуулсанд
баярлалаа!